# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ЗАХИРАМЖ

2013 оны 12 сарын 31-ний өдөр № 444/А - А/867 Улаанбаатар хот

Баянгол дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүд,
НИТХ, ДИТХ-ын төлөөлөгчид тойрогтоо ажиллах,
иргэдтэй уулзах, дүүргээс 2013 онд хийсэн ажлаа
тайлагнах ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Баянгол дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүд, НИТХ, ДИТХ-ын төлөөлөгчид тойрогтоо ажиллах, 2013 онд дүүргийн Засаг даргын Тамгын газраас иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл бололцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлаа иргэдэд тайлагнах уулзалт, хурлыг 2014 оны 01 дүгээр сарын 09-23-ны өдрүүдэд дүүргийн нийт 23 хороодод зохион байгуулсугай.

2. Иргэдтэй хийх уулзалтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар, хуваарийг гуравдугаар хавсралтаар, анонс болон зарын анонсын загварыг дөрөвдүгээр хавсралтаар, ажлын тайланг тараах тоо хэмжээг тавдугаар хавсралтаар, ажлын тайланг тараах дэд ажлын хэсгийг зургаадугаар хавсралтаар, уулзалтын байр, тоног төхөөрөмжийн бэлтгэлийг хангах дэд ажлын хэсгийг долоодугаар хавсралтаар, уулзалтаар иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, бүртгэж судлан шийдвэрлүүлэх, хариу өгөх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ажлын удирдамжийг мөрдлөг болгон, зохион байгуулалт сайтай ажиллан тулгамдсан асуудлаар Тамгын газрын болон харьяа хэлтэс, албадуудын төлөөллийг оролцуулах ажлыг зохион байгуулахыг Тамгын газар /Т.Нямцэцэг/, тайлангийн уулзалтын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба /М.Бадрах/, Иргэний танхимийн ерөнхий зохион байгуулагч /Ц.Уранбайгал/ нарт, уулзалтанд иргэдийг өргөнөөр хамруулах ажлыг зохион байгуулахыг хороодын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дүүргийн 23 хороодод зохион байгуулагдах тайлангийн уулзалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг нягтлан бодогч /Б.Дэлгэрмаа/-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллах нөхцөл боломж, удирдлага зохион байгуулалтаар хханган ажиллахыг Засаг даргын орлогч /П.Цэцэгмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Д.ДЭЛГЭРБАТ

ЗАСАГ ДАРГА Д.ОРОСОО

Баянгол дүүргийн ИТХ-ын дарга, Засаг даргын 2013 оны 12 сарын 27-ний өдрийн 444/...дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт
А-А/867

# УУЛЗАЛТ, ХУРЛЫН УДИРДАМЖ

***Уулзалт, хурлын зорилго:***

Баянгол дүүргийн шинэчлэлийн багаас 2013 онд төрийн үйлчилгээний шинэчлэл, ил тод нээлттэй, шуурхай байдлыг хангах, дүүрэг, хороодоо хөгжүүлэх, иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажилтай орлоготой болгох чиглэлээр хийсэн ажлуудаа иргэддээ тайлагнан тэдний санал, санаачлагыг үйл ажиллагаа, бодлого, шийдвэрт тусган хэрэгжүүлж, төр иргэний шууд холбоог нягтаршуулахад зорилго оршино.

***Зохион байгуулагдах хугацаа байршил :***

2013 оны 01 дүгээр сарын 09-23-ны өдрийг дуустал нийт 23 хороодын нутаг дэвсгэрт зохион байгуулагдана.

***Хамрах хүрээ:***

Баянгол дүүргийн нийт 23 хороодын иргэд

***Зохион байгуулах байгууллага:***

Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба
Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
Баянгол дүүргийн 23 хороодын ажлын алба

***Хуралд оролцох бүрэлдэхүүн:***

- Баянгол дүүргээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд,
- Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид,
- Дүүргийн удирдлагууд,
- Хороодын Засаг дарга нар
- Өмч, газрын харилцааны албаны дарга
- "Баянгол Шинэ өргөө" ОНӨААТҮГ-ын Захирал, дэд захирал
- Худалдаа, Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга
- Дэд Бүтэц, тохижилтын хэлтсийн дарга, мэргэжилтэн
- Хөдөлмөрийн хэлтсийн дарга, мэргэжилтэн
- Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга
- Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн нэгдлийн дарга
- Онцгой байдлын хэлтсийн дарга

***Хурлын зохион байгуулалт:***

Хурлын зохион байгуулалт 2 үе шаттай явагдана. Үүнд:

**А.Хурлын бэлтгэл хангах:**

- Зар мэдээ хүргэн иргэдийг өргөнөөр оролцуулан ирцийг хангана. /Хурлын зарыг 3-5 хоногийн өмнө иргэдэд хүргэсэн байх төдийгүй хорооны 150-аас доошгүй өрхийн төлөөллийг хамруулна./ Зарын нэгдсэн загварыг гаргаж өгнө.
- Хурал зохион байгуулах байр танхим, техник хэрэгслийг бэлтгэн анонс байршуулах;
- Бичгийн хэрэгсэл бэлтгэх;
- Баянголын шинэчлэлийн багаас 2013 онд зохион байгуулж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлангийн сэтгүүлийг иргэдэд тараах;
- Хийгдсэн телевизийн нэвтрүүлгийг уулзалт эхлэхийн өмнө танхимд гаргах.

**Б.Хурлын үйл ажиллагаа чиглэл :**

Хурлыг хороодын Засаг дарга нар удирдан зохион байгуулах бөгөөд Баянгол дүүргээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, Нийслэл, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Дүүргийн удирдлагууд, хэлтэс, албадын төлөөлөлөөс цаг үеийн болон дүүрэг хороодод тулгамдсан асуудлаар мэдээлэл, тайлбар хийнэ

Шинэчлэлийн багаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг таниулах, 2013 онд Баянгол дүүрэгт хэрэгжүүлж зохион байгуулсан онцлох шинэчлэлийн ажлын тухай болон дүүрэгт хийгдсэн хөрөнгө оруулалт томоохон бүтээн байгуулалтын ажлууд, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх чиглэлээр хороодод хийгдсэн ажлаа тайлагнана.

Иргэдийн санал, хүсэлтийг тэмдэглэх.

***<u>Хүрэх үр дүн:</u>***

- Хуралд оролцогчдын саналыг цаашдын үйл ажиллагаандаа тусгаж тодорхой чиглэлээр зөвлөмж боловсруулах;
- Иргэдийн санал санаачлагыг дүүрэг, хороодын Засаг даргын зорилт, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;
- Тайлангийн уулзалтаар төр засгийн зүгээс хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт өөрчлөлт, шинэчлэлийн ажлууд болон иргэдээ дэмжих зорилготой бодлого, арга хэмжээ, үйл ажиллагааг таниулах;
- Дүүрэг, хороодын хөгжилд хувь нэмэр болохуйц санал, санаачлагыг гаргаж бодит ажил хэрэг болгох боломж бүрдэнэ.
- Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, нээлттэй, шуурхай үзүүлэх чанар хүртээмжийг дээшлүүлэх, гарч буй сөрөг үзэгдэл, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлаар иргэдийнхээ санал санаачлагыг дэмжин цаашид авах арга хэмжээний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж шууд ардчилал иргэний оролцоог нэмэгдүүлнэ.

Баянгол дүүргийн ИТХ-ын дарга, Засаг
даргын 2013 оны 11 сарын 11-ний өдрийн
444/...дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт
11-А/167

# УУЛЗАЛТ, ХУРЛЫН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

| Д/д | Явагдах үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|
| 1 | Хурлыг нээж үг хэлнэ | 10 минут | Хороодын Засаг дарга нар |
| 2 | Шинэчлэлийн Засгийн газраас 2013 онд хэрэгжүүлсэн ажлын товч мэдээлэл УИХ-ын гишүүн, ХАХНХ-ын сайд С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн С.Одонтуяа, НИТХ, ДИТХ-ын төлөөлөгчид | 10 минут | Гишүүд, төлөөлөгчид |
| 3 | Баянгол дүүрэгт хийгдсэн ажлын тайлан (5А Зорилтын хүрээнд) | 20 минут | Засаг даргын орлогч П.Цэцэгмаа |
| 4 | Баянгол дүүрэгт 2013 онд хийгдсэн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын тайлан | 20 минут | Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс |
| 5 | Хорооны Засаг даргын ажлын тайлан | 20 минут | Хороодын Засаг дарга нар |
| 6 | Асуулт, хариулт | 40 минут | Баянгол дүүргээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, Нийслэл, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Дүүргийн удирдлагууд, хороодын Засаг дарга,дүүргийн Тамгын газрын болон харьяа хэлтсийн удирдлагууд |

ТАЙЛАНГИЙН ХУРЛЫН ХУВААРЬ

| № | Бүс | Хороод | Он сар өдөр | Цаг | Хаана |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 дугаар бүс | 5 дугаар хороо | 2014.01.09 | 18.30 | Хорооны иргэний танхимд |
| 2 | | 6 дугаар хороо | 2014.01.10 | 18.30 | Баянгол дүүргийн 43 дугаар сургуулийн хурлын танхимд |
| 3 | | 7 дугаар хороо | 2014.01.11 | 12.00 | Баянгол дүүргийн 78 дугаар сургуулийн хурлын танхимд |
| 4 | | 8 дугаар хороо | 2014.01.11 | 15.00 | Баянгол дүүргийн 93 дугаар сургуулийн хурлын танхимд |
| 5 | | 9 дүгээр хороо | 2014.01.11 | 18.00 | Баянгол дүүргийн 113 дугаар сургуулийн хурлын танхимд |
| 6 | | 21 дүгээр хороо | 2014.01.12 | 11.30 | Хорооны иргэний танхимд |
| 7 | 3 дугаар бүс | 10 дугаар хороо | 2014.01.12 | 15.00 | Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн урлаг танхимд |
| 8 | | 11 дүгээр хороо | 2014.01.13 | 18.30 | Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн хурлын танхимд |
| 9 | | 12 дугаар хороо | 2014.01.14 | 18.30 | Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн урлагын танхимд |
| 10 | | 13 дугаар хороо | 2014.01.15 | 18.30 | Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн урлаг зааланд |
| 11 | | 14 дүгээр хороо | 2014.01.16 | 18.30 | Баянгол дүүргийн 85 дугаар цэцэрлэгийн урлаг зааланд |
| 12 | | 22 дугаар хороо | 2014.01.12 | 18.00 | Хорооны иргэний тэнхимд |
| 13 | | 23 дугаар хороо | 2014.01.17 | 18.30 | Хорооны иргэний тэнхимд |
| 14 | 4 дүгээр бүс | 15 дугаар хороо | 2014.01.19 | 12.00 | 40 дүгээр сургуулийн хурлын зааланд |
| 15 | | 16 дугаар хороо | 2014.01.19 | 15.00 | Иргэний тэнхимд |
| 16 | | 17 дугаар хороо | 2014.01.18 | 12.00 | 96 дугаар сургуулийн хурлын зааланд |
| 17 | | 18 дугаар хороо | 2014.01.18 | 18.00 | Баянгол дүүргийн 96 дугаар сургуулийн хурлын зааланд |
| 18 | | 19 дүгээр хороо | 2014.01.18 | 15.00 | Баянгол дүүргийн 47 дугаар сургуулийн хурлын зааланд |
| 19 | 1 дүгээр бүс | 1 дүгээр хороо | 2014.01.19 | 18.00 | Хорооны Иргэний танхимд |
| 20 | | 2 дугаар хороо | 2014.01.20 | 18.30 | Төмөр замын дуу бүжгийн чуулгын урлагийн танхимд |
| 21 | | 3 дугаар хороо | 2014.01.21 | 18.30 | Ахмадын өргөөнд |
| 22 | | 4 дүгээр хороо | 2014.01.22 | 18.30 | Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд |
| 23 | | 20 дугаар хороо | 2014.01.23 | 18.30 | Баянгол дүүргийн 19 дүгээр сургуулийн зааланд |

Баянгол дүүргийн ИТХ-ын дарга, Засаг
даргын 2013 оны 12 сарын 31-ний өдрийн
444/ А-А/164 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

УУЛЗАЛТ, ХУРЛЫН БОЛОН ЗАРЫН АНОНСЫН ЗАГВАР

Баянгол дүүргийн ИТХ-ын дарга, Засаг даргын 2013 оны 11 сарын 11-ний өдрийн 444/А-А/167 дугаар захирамжийн тавдугаар хавсралт

## ТАЙЛАНГ ТАРААХ ТОО ХЭМЖЭЭ

| № | УИХ | Засаг даргын тайлан | Хурлын тайлан | бүс | НИТХ тайлан тоо | хороо | хорооны тайлангийн тоо | Хурлын төлөөлөгчийн тайлангийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 45000 | 45000 | 45000 | 1-р бүс | 11750 | 1 дүгээр хороо | 3800 | 3800 |
| 2 | | | | | | 2 дугаар хороо | 1650 | 1650 |
| 3 | | | | | | 3 дугаар хороо | 1550 | 1550 |
| 4 | | | | | | 4 дүгээр хороо | 3000 | 3000 |
| 5 | | | | | | 20 дугаар хороо | 1750 | 1750 |
| 6 | | | | 2-р бүс | 14150 | 5 дугаар хороо | 2100 | 2100 |
| 7 | | | | | | 6 дугаар хороо | 3900 | 3900 |
| 8 | | | | | | 7 дугаар хороо | 2500 | 2500 |
| 9 | | | | | | 8 дугаар хороо | 2450 | 2450 |
| 10 | | | | | | 9 дүгээр хороо | 1500 | 1500 |
| 11 | | | | | | 21 дүгээр хороо | 1700 | 1700 |
| 12 | | | | 3-р бүс | 10900 | 10 дүгээр хороо | 1900 | 1900 |
| 13 | | | | | | 11 дүгээр хороо | 1500 | 1500 |
| 14 | | | | | | 12 дугаар хороо | 2400 | 2400 |
| 15 | | | | | | 13 дугаар хороо | 900 | 900 |
| 16 | | | | | | 14 дүгээр хороо | 1100 | 1100 |
| 17 | | | | | | 22 дугаар хороо | 1800 | 1800 |
| 18 | | | | | | 23 дугаар хороо | 1300 | 1300 |
| 19 | | | | 4-р бүс | 8200 | 15 дугаар хороо | 1100 | 1100 |
| 20 | | | | | | 16 дугаар хороо | 1700 | 1700 |
| 21 | | | | | | 17 дугаар хороо | 1900 | 1900 |
| 22 | | | | | | 18 дугаар хороо | 2200 | 2200 |
| 23 | | | | | | 19 дүгээр хороо | 1300 | 1300 |
| НИЙТ ТОО | | | | | | | 45000 | |

Баянгол дүүргийн ИТХ-ын дарга, Засаг даргын 2013 оны ...сарын...ний өдрийн ....дугаар захирамжийн зургаадугаар хавсралт

## ТАЙЛАНГ ТАРААХ ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

| № | Ажлын хэсэг | Ажлын хэсгийн дарга | Нарийн бичгийн дарга | Хороо |
|---|---|---|---|---|
| 1 | Хоёрдугаар дэд ажлын хэсэг | Б.Алтангэрэл | У.Төмөрхуяг | 5 дугаар хороо |
| 2 | | | Ш.Даваанямм | 6 дугаар хороо |
| 3 | | | М.Алтанцэцэг | 7 дугаар хороо |
| 4 | | | Б.Алтангэрэл | 8 дугаар хороо |
| 5 | | | Ц.Энхтүвшин | 9 дүгээр хороо |
| 6 | | | Х.Өлзийтогтох | 21 дүгээр хороо |
| 7 | Гуравдугаар дэд ажлын хэсэг | Х.Ганхуяг | З.Төгсбаяр | 10 дугаар хороо |
| 8 | | | Д.Эрдэнэтуяа | 11 дүгээр хороо |
| 9 | | | Х.Ганхуяг | 12 дугаар хороо |
| 10 | | | А.Эрдэнэ | 13 дугаар хороо |
| 11 | | | Д.Нансалмаа | 14 дүгээр хороо |
| 12 | | | Л.Оюун | 22 дугаар хороо |
| 13 | | | Ц.Оюунцэцэг | 23 дугаар хороо |
| 14 | Дөрөвдүгээр дэд ажлын хэсэг | Т.Пүрэвсүрэн | Ж.Ариунханд | 15 дугаар хороо |
| 15 | | | Д.Отгонлхам | 16 дугаар хороо |
| 16 | | | Саруул | 17 дугаар хороо |
| 17 | | | Ш.Шагдаржав | 18 дугаар хороо |
| 18 | | | Т.Пүрэвсүрэн | 19 дүгээр хороо |
| 19 | Нэгдүгээр дэд ажлын хэсэг | Ё.Ариунзул | Р.Одонтунгалаг | 1 дүгээр хороо |
| 20 | | | Ё.Ариунзул | 2 дугаар хороо |
| 21 | | | Б.Ганболд | 3 дугаар хороо |
| 22 | | | Д.Дорждулам | 4 дүгээр хороо |
| 23 | | | Б.Дамба | 20 дугаар хороо |

Баянгол дүүргийн ИТХ-ын дарга, Засаг даргын 2013 оны 12 сарын 31-ний өдрийн 444/A-A/867 дугаар захирамжийн долоодугаар хавсралт

## УУЛЗАЛТЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Ажлын хэсэг | Ажлын хэсгийн дарга | Гишүүд | Хороо |
|---|---|---|---|---|
| 1 | Хоёрдугаар дэд ажлын хэсэг | Б.Алтангэрэл | У.Төмөрхуяг-Хорооны Засаг дарга<br>Н.Оюунхүү-Иргэний танхимын зохион байгуулагч | 5 дугаар хороо |
| 2 | | | Ш.Даваанямм-Хорооны Засаг дарга<br>Л.Алтанзул-Иргэний танхимын зохион байгуулагч | 6 дугаар хороо |
| 3 | | | М.Алтанцэцэг-Хорооны Засаг дарга<br>Г.Уянга-Иргэний танхимын зохион байгуулагч | 7 дугаар хороо |
| 4 | | | Г.Отгонжаргал-Иргэний танхимын зохион байгуулагч | 8 дугаар хороо |
| 5 | | | Ц.Энхтүвшин- Хорооны Засаг дарга<br>Б.Золжаргал-Иргэний танхимын зохион байгуулагч | 9 дүгээр хороо |
| 6 | | | Х.Өлзийтогтох-Хорооны Засаг дарга<br>С.Мөнхцэцэг-Иргэний танхимын зохион байгуулагч | 21 дүгээр хороо |
| 7 | Гуравдугаар дэд ажлын хэсэг | Х.Ганхуяг | З.Төгсбаяр-Хорооны Засаг дарга<br>Г.Дэлгэржаргал-Иргэний танхимын зохион байгуулагч | 10 дугаар хороо |
| 8 | | | Д.Эрдэнэтуяа-Хорооны Засаг дарга<br>С.Баярмагнай-Иргэний танхимын зохион байгуулагч | 11 дүгээр хороо |
| 9 | | | Д.Цэцэгбал-Иргэний танхимын зохион байгуулагч | 12 дугаар хороо |
| 10 | | | А.Эрдэнэ-Хорооны Засаг дарга<br>Ч.Жавзмаа-Иргэний танхимын зохион байгуулагч | 13 дугаар хороо |
| 11 | | | Д.Нансалмаа-Хорооны Засаг дарга<br>Ч.Балжмаа-Иргэний танхимын зохион байгуулагч | 14 дүгээр хороо |
| 12 | | | Л.Оюун-Хорооны Засаг дарга<br>Д.Ариунчимэг-Иргэний танхимын зохион байгуулагч | 22 дугаар хороо |
| 13 | | | Ц.Оюунцэцэг-Хорооны Засаг дарга<br>О.Мөнх-Эрдэнэ-Иргэний танхимын зохион байгуулагч | 23 дугаар хороо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14 | Дөрөвдүгээр дэд ажлын хэсэг | Т.Пүрэвсүрэн | Ж.Ариунханд-Хорооны Засаг дарга | 15 дугаар хороо |
| | | | В.Мөнхжаргал-Иргэний танхимын зохион байгуулагч | |
| 15 | | | Д.Отгонлхам-Хорооны Засаг дарга | 16 дугаар хороо |
| | | | Н.Оюунбилэг-Иргэний танхимын зохион байгуулагч | |
| 16 | | | Саруул-Хорооны Засаг дарга | 17 дугаар хороо |
| | | | Б.Эрдэнэбаяр-Иргэний танхимын зохион байгуулагч | |
| 17 | | | Ш.Шагдаржав-Хорооны Засаг дарга | 18 дугаар хороо |
| | | | Г.Алтанчимэг-Иргэний танхимын зохион байгуулагч | |
| 18 | | | Ц.Баярмаа-Иргэний танхимын зохион байгуулагч | 19 дүгээр хороо |
| 19 | Нэгдүгээр дэд ажлын хэсэг | Ё.Ариунзул | Р.Одонтунгалаг-Хорооны Засаг дарга | 1 дүгээр хороо |
| | | | Э.Наранцэцэг | |
| 20 | | | П.Нямцэцэг-Иргэний танхимын зохион байгуулагч | 2 дугаар хороо |
| 21 | | | Б.Ганболд-Хорооны Засаг дарга | 3 дугаар хороо |
| | | | М.Мөнхмаа-Иргэний танхимын зохион байгуулагч | |
| 22 | | | Д.Дорждулам-Хорооны Засаг дарга | 4 дүгээр хороо |
| | | | П.Бат-Өлзий-Иргэний танхимын зохион байгуулагч | |
| 23 | | | Б.Дамба-Хорооны Засаг дарга | 20 дугаар хороо |
| | | | Ц.Нансалмаа-Иргэний танхимын зохион байгуулагч | |

Баянгол дүүргийн ИТХ-ын дарга, Засаг даргын 2013 оны 12 сарын 11-ний өдрийн ….дугаар захирамжийн наймдугаар хавсралт

# УУЛЗАЛТ, ХУРЛААР ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭЖ СУДЛАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ, ХАРИУ ӨГӨХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|---|---|---|
| Дарга: | Т.УУГАНБАЯР | Тамгын газрын дэд дарга |
| Нарийн бичгийн дарга: | Д.ГЭРЭЛЭЭ | Тамгын газрын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн |
| | П.МӨНХЧИМЭГ | Захиргаа, хуулийн хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан ажилтан |
| | Б.ЭРДЭНЭТУЯА | Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан ажилтан |
| | Д.АРИУНАА | Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн |
| | | Өмч, газрын харилцааны албаны мэргэжилтэн |
| | | Мэргэжлийн хяналтын хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан ажилтан |
| | | "Баянгол Шинэ өргөө" ОНӨААТҮГ-ын Эрх зүйн мэргэжилтэн |
| | | Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан ажилтан |
| | | Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан ажилтан |
| | | Замын цагдаагийн тасгийн өргөдөл гомдол хариуцсан ажилтан |
| | | Эрүүл мэндийн нэгдлийн өрхийн эмнэлэг хариуцсан ажилтан |

Лого

***ДҮҮРГИЙНХЭЭ ШИНЭЧЛЭЛ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨӨ ХАМТДАА***

## УРИЛГА

Баянгол дүүрэгт 2013 онд хийгдсэн ажлын тайлан, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар иргэддээ тайлагнах, санал хүсэлтийг хүлээн авах уулзалтад урьж байна.

Уулзалтад дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн ХАХНХ-ын яамны сайд С.Эрдэнэ, УИХ-ын нишүүн С.Одонтуяа, НИТХ, ДИТХ-ын төлөөлөгчид болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдлагууд оролцоно. Та бүхэн хүрэлцэн ирж, дүүргийнхээ хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулахыг хүсье.

ХУВААРЬ:

| Бүс | Хороод | Он сар өдөр | Цаг | Хаана |
|---|---|---|---|---|
| 2 дугаар бүс | 5 дугаар хороо | 2014.01.09 | 18.30 | Хорооны иргэний танхимд |
| | 6 дугаар хороо | 2014.01.10 | 18.30 | Баянгол дүүргийн 43 дугаар сургуулийн хурлын танхимд |
| | 7 дугаар хороо | 2014.01.11 | 12.00 | Баянгол дүүргийн 78 дугаар сургуулийн хурлын танхимд |
| | 8 дугаар хороо | 2014.01.11 | 15.00 | Баянгол дүүргийн 93 дугаар сургуулийн хурлын танхимд |
| | 9 дүгээр хороо | 2014.01.11 | 18.00 | Баянгол дүүргийн 113 дугаар сургуулийн хурлын танхимд |
| | 21 дүгээр хороо | 2014.01.12 | 11.30 | Хорооны иргэний танхимд |
| 3 дугаар бүс | 10 дугаар хороо | 2014.01.12 | 15.00 | Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн урлаг танхимд |
| | 11 дүгээр хороо | 2014.01.13 | 18.30 | Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн хурлын танхимд |
| | 12 дугаар хороо | 2014.01.14 | 18.30 | Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн урлагын танхимд |
| | 13 дугаар хороо | 2014.01.15 | 18.30 | Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн урлаг зааланд |
| | 14 дүгээр хороо | 2014.01.16 | 18.30 | Баянгол дүүргийн 85 дугаар цэцэрлэгийн урлаг зааланд |
| | 22 дугаар хороо | 2014.01.12 | 18.00 | Хорооны иргэний тэнхимд |
| | 23 дугаар хороо | 2014.01.17 | 18.30 | Хорооны иргэний тэнхимд |

Дэлгэрэнгүй мэдээллийг: 99091340,70120321
www.bgd.mn

Лого

***ДҮҮРГИЙНХЭЭ ШИНЭЧЛЭЛ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨӨ ХАМТДАА***

## УРИЛГА

Баянгол дүүрэгт 2013 онд хийгдсэн ажлын тайлан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар иргэддээ тайлагнах, санал хүсэлтийг хүлээн авах уулзалтад урьж байна.

Уулзалтад дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүд, НИТХ, ДИХТ-ын төлөөлөгчид болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдлагууд оролцоно. Та бүхэн хүрэлцэн ирж, дүүргийнхээ хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулахыг хүсье.

ХУВААРЬ:

| Бүс | Хороод | Он сар өдөр | Цаг | Хаана |
|---|---|---|---|---|
| 4 дүгээр бүс | 15 дугаар хороо | 2014.01.19 | 12.00 | 40 дүгээр сургуулийн хурлын зааланд |
| | 16 дугаар хороо | 2014.01.19 | 15.00 | Иргэний тэнхимд |
| | 17 дугаар хороо | 2014.01.18 | 12.00 | 96 дугаар сургуулийн хурлын зааланд |
| | 18 дугаар хороо | 2014.01.18 | 18.00 | Баянгол дүүргийн 96 дугаар сургуулийн хурлын зааланд |
| | 19 дүгээр хороо | 2014.01.18 | 15.00 | Баянгол дүүргийн 47 дугаар сургуулийн хурлын зааланд |
| 1 дүгээр бүс | 1 дүгээр хороо | 2014.01.19 | 18.00 | Хорооны Иргэний танхимд |
| | 2 дугаар хороо | 2014.01.20 | 18.30 | Төмөр замын дуу бүжгийн чуулгын урлагийн танхимд |
| | 3 дугаар хороо | 2014.01.21 | 18.30 | Ахмадын өргөөнд |
| | 4 дүгээр хороо | 2014.01.22 | 18.30 | Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд |
| | 20 дугаар хороо | 2014.01.23 | 18.30 | Баянгол дүүргийн 19 дүгээр сургуулийн зааланд |

Дэлгэрэнгүй мэдээллийг: 99091340,70120321
www.bgd.mn